



**ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2022 оны 02 сарын 10 өдөр

Дугаар 07/05

Эрдэнэт


2022 онд ойгоос бэлтгэх модны
дээд хэмжээ батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх заалт, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2 дахь заалт, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалт, 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсэг, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2021 оны А/217 дугаар тушаалыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит VII хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Аймгийн 2018 оны ойн зохион байгуулалтын ажлын тайлан, ойн менежмент төлөвлөгөөг харгалзан 2022 онд аймгийн хэмжээнд ойгоос бэлтгэх модны дээд хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Холбогдох хууль, тогтоомж, журмын дагуу ойгоос бэлтгэх модны төрөл тоо, хэмжээг нөхөрлөл, аж ахуйн нэгж байгууллага тус бүрээр тогтоохыг Баян-Өндөр, Жаргалант сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тус тус зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д. МӨНХБАТ

079130013

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022
оны 02 дугаар сарын 10-ны өдрийн Ээлжит VII
хуралдааны 11 дүгээр тогтоолын хавсралт



ОЙГООС БЭЛТГЭХ МОДНЫ ДЭЭД ХЭМЖЭЭ

Сумын нэр	Цэвэрлэгээний огтлолт			Цэвэрлэгээний ажил		
	Хэрэглээ (м ³)	Түлээ (м ³)	Талбайн хэмжээ (га)	Хэрэглээ (м ³)	Түлээ (м ³)	Талбайн хэмжээ (га)
Баян-өндөр	-	-	-	-	550	69
Жаргалант	550	193	21	200	2150	300
Нийт	550	193	21	200	2650	369

-оОо-